

Завхан аймгийн Нийгмийн  
даатгалын газрын гэрээт харуул  
С.Балжиннямын хагас жилийн  
гүйцэтгэлийн тайлан

Улиастай сум  
2024 он

## Нийгмийн даатгалын газрын гэрээт харуул

### С.Балжиннямын 2024 оны хагас жилийн ажлын тайлан

- Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажилласан бөгөөд дутагдсан ,алдагдсан эд хөрөнгө байхгүй болно.
- Шаардлагатай үед шөнийн цагаар хяналт хийж ажилласан. Ямар нэгэн зөрчил гараагүй болно.
- Эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал хангаж 24 цагийн турш утсыг нээлттэй байлгаж ажилласан.
- Байгууллагын шинэ хаяг суурилуулж хийхэд оролцсон.
- Хуульчийн про өдөр нээлттэй хаалганы өдөрлөгт үйлчилгээний ажил хийж оролцсон.
- Бүх нийтийн мод тарих өдөр мод тарих ажилд оролцсон.
- Гамшгийн үеийн бэлэн байдлын сургалтанд оролцсон.
- Эрчим хүчний ажилтнуудтай хамтран цахилгааны утас далдлах ,шит зөөх ажилд оролцсон.
- Нийгмийн хамгааллын ажилтны өдөрт зориулан зохиогдсон тэмцээн уралдаанд багаар хамтран оролцсон.
- “Амар амгалан баруун бүс “ нийгмийн даатгалын багц хуулийг сурталчлан таниулах уулзалтанд оролцсон.
- Байгууллагын дотоод тохижилт үйлчилгээний хаяг солих , зурагт суурилуулах хөшиг солих, гэрэл шинэчлэх, тэтгэврийн хувийн хэрэг хадгалах, сейфний бүх цоожийг засах солих ажилд оролцсон.
- Бүх өрөөний эмульс засвар хийх ажилд оролцсон.
- Байгууллагад үйлчилгээ авахаар ирсэн иргэн даатгуулагчдад хэв журам сахиулж ёс зүйн алдаа гаргаагүй ажилласан.
- Шаардлагатай үед даатгуулагчийн уулзах байцаагч ,албан тушаалтны нэр ,өрөөг танилцуулж чиглүүлэг өгч ажилласан.
- Цахилгаан ,дулаан,ус түгээгүүрийн хэвийн ажиллагааг хянаж шаардлагатай үед засах зэрэг ажил хийсэн. Архивын өрөөний паарны ус алдалтыг тогтоох засах , разетка засаж янзлах зэрэг ажилд оролцсон. Паарнаас хий авах, зэрэг ажил хийсэн.
- Камер дохиоллын бүрэн бүтэн байдал ,хэвийн ажиллагааг хянаж шаардлагатай тохиолдолд байгууллагын удирдлага болон сүлжээний ажилтанд мэдэгдсэн.
- Харуулын үүрэг гүйцэтгэсэн талаарх тэмдэглэлийг өдөр бүр хөтөлж шаардлага гарсан тухай бүр хэлтсийн даргад танилцуулсан.
- Ажлын бус цаг,амралтын өдрүүдэд ажилласан ажилчдын тэмдэглэл хөтөлж ажилласан.
- Байгууллагад эд хөрөнгө бусад зүйлсийг оруулж гаргахыг удирдлагын зөвшөөрлөөр гүйцэтгэж тэмдэглэл хөтлөх, гарын үсэг зуруулж баталгаажуулсан.

- Байгууллагыг нээж, хаах, дохиололд холбож, хамгаалалтанд орсон тухай мэдээлэл авч харуулын албаны ээлжийн ахлагчтай хамтарч ажилласан.
- Хог хаягдлыг цэвэрлэгээний машинд лхагва гариг бүрт тогтмол ачуулсан. Хаврын их цэвэрлэгээний ажилд оролцсон.
- Граш руу ус орохоос сэргийлж суваг шуудууг ухаж далан хийх ажилд оролцсон.
- Байгууллагын нууцыг чандлан сахиж ажилласан.
- Иргэд даатгуулагчдаас ямар нэг гомдол, санал гараагүй болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

ГЭРЭЭТ ХАРУУЛ

*С.Балжинням*

С.БАЛЖИННЯМ

2024.06.10







